

## ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2017 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2017 оны 05 сарын 18

Улаанбаатар хот

### НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

Тайлант улиралд 2 ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, 16 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, 3 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудлыг Хорооны хуралдаанаар шийдвэрлэж 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 282 хадгаламж, зээлийн хоршоо /цаашид “ХЗХ” гэх/ Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.


ХЗХ-дыг үйл ажиллагааны төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ХЗХ-дын тоо	
		2016 онд	2017 оны I улирал
1	Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй	280	282
	<b>Үүнээс:</b>		
2	Төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй	123	123
3	Санхүүгийн түрээсийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй	1	2
4	Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа	1	1

ХЗХ-дын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлуудыг Хорооны хуралдаанаар шийдвэрлэснийг он болон төрөл тус бүрээр харуулбал:

Он	Шинээр олгосон	Хүчингүй болгосон	Түдгэлзүүлсэн	Сэргээсэн	ТЗ-ийн хугацаа сунгасан	ХЗХ-дын тоо (оны эцэст)
2006 он	51	-	-	-	-	<b>51</b>
2007 он	128	-	-	-	-	<b>179</b>
2008 он	45	15	5	-	-	<b>209</b>
2009 он	15	12	8	1	25	<b>212</b>
2010 он	2	35	15	4	80	<b>179</b>
2011 он	4	21	9	-	47	<b>162</b>
2012 он	3	17	7	4	26	<b>148</b>
2013 он	2	9	5	-	76	<b>141</b>
2014 он	25	7	7	3	28	<b>159</b>
2015 он	98	4	1	1	21	<b>253</b>
2016 он	34	7	2	-	48	<b>280</b>
2017 оны I улирал	2	-	3	-	16	<b>282</b>
<b>Дүн</b>	<b>409</b>	<b>127</b>	<b>62</b>	<b>13</b>	<b>367</b>	

ХЗХ-дын тооны өөрчлөлтийг сүүлийн 5 жилийн байдлаар харуулбал:



ХЗХ-дын гишүүдийн тооны сүүлийн 5 жилийн өөрчлөлтийг харуулбал:



## ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөл бүхий 282 ХЗХ-ноос өмнөх улирлаар 23 ХЗХ, эхлэлтийн тайлангийн дүнгээр 7 ХЗХ нэгтгэлд хамрагдсан байна.

### 2.1 Гишүүдийн статистик үзүүлэлтүүд

(тоогоор)

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	НИЙТ 282 ХЗХ-ДЫН ГИШҮҮДИЙН		ҮҮНЭЭС:			
			Улаанбаатар хотын 185 ХЗХ		Орон нутгийн 97 ХЗХ	
Гишүүдийн	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт гишүүдийн тоо	47,918	100%	27,696	100%	20,222	100%
Үүнээс: эмэгтэй	27,172	56.7%	16,786	60.6%	10,386	51.4%
Үүнээс: гишүүн хуулийн этгээд	646	1.3%	355	1.3%	291	1.4%
Гишүүдийн насжилт	47,918	100%	27,696	100%	20,222	100%
18-35 насны	13,787	28.8%	8,291	29.9%	5,496	27.2%
36-45 насны	14,570	30.4%	8,110	29.3%	6,460	31.9%
46-55 насны	11,922	24.9%	6,688	24.1%	5,234	25.9%

55-аас дээш	7,639	15.9%	4,607	16.6%	3,032	15.0%
Гишүүдийн боловсрол	47,917	100%	27,695	100%	20,222	100%
Дээд	22,000	45.9%	15,756	56.9%	6,244	30.9%
Тусгай дунд	7,814	16.3%	4,424	16.0%	3,390	16.8%
Бүрэн дунд	10,633	22.2%	5,397	19.5%	5,236	25.9%
Дунд	5,352	11.2%	1,442	5.2%	3,910	19.3%
Бага	2,118	4.4%	676	2.4%	1,442	7.1%
Нийт ажилчдын тоо	738	100%	485	100%	253	100%
Эмэгтэй ажилчдын тоо	544	73.7%	359	74.0%	185	73.1%
Санхүүгийн програм хангамжийн тоо	185	65.6%	145	78.3%	41	42.3%

Тайлант улиралд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 282 ХЗХ-ны нийт гишүүдийн тоо 47,918-д хүрсэн байгаа нь өмнөх оны мөн үеэс 6,101 гишүүнээр, өмнөх улирлаас 1,735 гишүүнээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Мөн нийт гишүүдийн 20,222 буюу 42.2 хувь нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа 97 ХЗХ-ны гишүүд, 27,696 буюу 57.8 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 185 ХЗХ-ны гишүүд байна.

## 2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2016 оны I улирал	2017 оны I улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	ХЗХ-дын тоо	271	282	11	4.1%
2	Гишүүдийн тоо	41,817	47,918	6,101	14.6%
3	Нийт актив	101,526,431.9	121,698,281.4	20,171,849.5	19.9%
	Банкны салбарт эзлэх хувь	0.50%	0.50%	-	-
4	Нийт зээлийн үлдэгдэл	80,318,082.9	96,733,750.1	16,415,667.2	20.4%
	Банкны салбарт эзлэх хувь	0.70%	0.70%	-	-
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	3,457,100.7	4,484,903.8	1,027,803.1	29.7%
	Банкны салбарт эзлэх хувь	0.40%	0.40%	-	-
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	62,808,344.1	74,658,800.4	11,850,456.3	18.9%
	Банкны салбарт эзлэх хувь	0.80%	0.80%	-	-
7	Нийт хувь хөрөнгийн үлдэгдэл	11,107,870.4	13,421,048.9	2,313,178.5	20.8%
8	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл	9,365,709.0	10,053,107.1	687,398.1	7.3%
9	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн дүн	11,882,476.1	16,833,370.5	4,950,894.4	41.6%
10	Нийт орлого	6,077,367.5	6,934,210.3	856,842.8	14.1%
11	Нийт зардал	5,454,968.2	6,450,139.9	995,171.7	18.2%
12	Тухайн үеийн ашиг, алдагдал	622,399.3	484,070.4	-138,328.90	(22.2)

Тайлант улиралд ХЗХ-ны тоо өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар, гишүүдийн тоо 14.6 хувиар, нийт активын хэмжээ 19.9 хувиар тус тус өссөн байна. ХЗХ-ны салбарын чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 29.7 хувиар өссөн, тайлант үеийн цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 138,328.90 мянган төгрөгөөр буюу 22.2 хувиар буурсан байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 282 ХЗХ-ноос 65.6 хувь буюу 185 ХЗХ нь Улаанбаатар хотод, 34.4 хувь буюу 97 ХЗХ нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ба тайлант улиралд Хөвсгөл аймагт 1 ХЗХ шинээр байгуулагдсан байна.

Орон нутгийн ХЗХ-дыг байршлаар нь үзүүлбэл:



### 2.3 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2016 оны I улирал	2017 оны I улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	УБ хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	175	185	10	5.7%
2	Гишүүдийн тоо	24,116	27,696	3,580	14.8%
	ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь	57.7%	57.8%	0.1%	0.2%
3	Нийт актив	87,192,391.4	105,108,897.1	17,916,505.7	20.5%
	ХЗХ-ны нийт активт эзлэх хувь	85.9%	86.4%	0.5%	0.5%
4	Нийт зээлийн үлдэгдэл	69,138,567.3	83,908,527.7	14,769,960.4	21.4%
	ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	86.1%	86.7%	0.6%	0.7%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	2,970,719.5	3,939,645.7	968,926.2	32.6%
	ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь	85.9%	87.8%	1.9%	2.3%
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл	55,218,764.2	65,601,318.4	10,382,554.2	18.8%
	ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь	87.9%	87.9%	-	-
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	7,881,261.5	9,680,182.4	1,798,920.9	22.8%

	<i>ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	71%	72.1%	1.1%	1.5%
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн	7,572,065.2	7,821,148.2	249,083.0	3.3%
	<i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>	80.8%	77.8	(3.0%)	(3.7%)
9	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн дүн	11,832,549.5	16,084,449.5	4,251,900.0	35.9%
10	Нийт орлого	4,793,800.2	5,477,565.8	683,765.6	14.3%
11	Нийт зардал	4,161,400.1	5,211,691.4	1,050,291.3	25.2%
12	Тухайн үеийн ашиг, алдагдал	632,400.1	265,874.4	-366,525.7	(58.0%)

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 185 ХЗХ-ны нийт актив 105,108,897.1 мянган төгрөг байгаа нь салбарын нийт активын 86.4 хувийг, нийт орлого 5,477,565.8 мянган төгрөг байгаа нь ХЗХ-дын нийт орлогын 79.0 хувийг, нийт зардал 5,211,691.4 мянган төгрөг байгаа нь нийт зардлын 80.8 хувийг тус тус эзэлж байна.

#### 2.4 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2016 оны I улирал	2017 оны I улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	96	97	1	1.0%
2	Гишүүдийн тоо	17,701	20,222	2,521	14.2%
	<i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i>	42.3%	42.2%	(0.1%)	(0.2%)
3	Нийт актив	14,334,040.5	16,589,384.3	2,255,343.8	15.7%
	<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	14.1%	13.6%	(0.5%)	(3.3%)
4	Нийт зээлийн үлдэгдэл	11,179,515.5	12,825,222.4	1,645,706.9	14.7%
	<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	13.9%	13.3%	(0.6%)	(4.6%)
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	486,381.1	545,258.1	58,877.0	12.1%
	<i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	14.1%	12.2%	(1.9%)	(13.8%)
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл	7,589,579.9	9,057,481.9	1,467,902.0	19.3%
	<i>ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	12.1%	12.1%	-	-
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	3,226,608.9	3,740,866.5	514,257.6	15.9%
	<i>ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	29.0%	27.9%	(1.1%)	(3.9%)
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн	1,793,643.8	2,231,958.8	438,315.0	24.4%
	<i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>	19.2%	22.2%	3.0%	15.6%
9	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн дүн	49,926.6	748,921.0	698,994.4	1,400%
10	Нийт орлого	1,283,567.2	1,456,644.4	173,077.2	13.5%
11	Нийт зардал	1,293,568.1	1,238,448.4	(55,119.7)	(4.3%)
12	Тухайн үеийн ашиг	-10,000.9	218,196.0	208,195.1	(2,081.8%)

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 97 ХЗХ-ны нийт актив 16,589,384.3 мянган төгрөг байгаа нь салбарын нийт активын 13.6 хувийг, нийт орлого 1,456,644.4 мянган төгрөг байгаа нь нийт орлогын 21.0 хувийг, нийт зардал 1,238,448.4 мянган төгрөг байгаа нь нийт зардлын 19.2 хувийг тус тус эзэлж байна.

## 2.5 Нийслэлийн "Бичил бизнесийг дэмжих ядуурлыг бууруулах хөтөлбөр"-ийн хүрээнд зээл авсан буюу төслийн хүрээнд байгуулагдсан 118 ХЗХ-ны статистик үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2016 оны I улирал	2017 оны I улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	ХЗХ-дын тоо	107	118	11	10.3%
2	Гишүүдийн тоо	7,021	9,485	2,464	35.1%
	<i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i>	<i>16.8%</i>	<i>19.8%</i>	<i>3.0%</i>	<i>17.8%</i>
3	Нийт актив	10,709,566.5	13,478,756.9	2,769,190.4	25.9%
	<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	<i>10.5%</i>	<i>11.1%</i>	<i>0.6%</i>	<i>5.7%</i>
4	Нийт зээлийн үлдэгдэл	9,941,691.9	11,997,002.5	2,055,310.6	20.7%
	<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>12.4%</i>	<i>12.4%</i>	-	-
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	195,143.1	339,334.5	144,191.4	73.9%
	<i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>5.6%</i>	<i>7.6%</i>	<i>2.0%</i>	<i>35.7%</i>
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл	458,410.7	1,096,459.9	638,049.2	139.2%
	<i>ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>0.7%</i>	<i>1.5%</i>	<i>0.8%</i>	<i>114.3%</i>
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	478,844.4	731,643.6	252,799.2	52.8%
	<i>ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>4.3%</i>	<i>5.5%</i>	<i>1.2%</i>	<i>27.9%</i>
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн	(152,550.6)	(151,446.5)	1,104.0	0.7%
	<i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>	<i>(1.6%)</i>	<i>(1.5%)</i>	<i>0.1%</i>	<i>6.3%</i>
9	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн дүн	9,806,664.8	11,623,912.8	1,817,248.0	18.5%
	<i>ХЗХ-ны нийт авсан зээлийн дүнд эзлэх хувь</i>	<i>82.5%</i>	<i>69.1%</i>	<i>(13.4%)</i>	<i>(16.2%)</i>
10	Нийт орлого	432,456.2	568,468.4	136,012.2	31.5%
11	Нийт зардал	487,608.8	676,193.1	188,584.3	38.7%
12	Тухайн үеийн ашиг	(55,152.6)	(107,724.7)	(52,572.1)	95.3%

Хорооноос төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх зөвшөөрөл авч, "Бичил бизнесийг дэмжих Нийслэлийн хөтөлбөр"-т хамрагдсан 123 ХЗХ байгаагаас 118 ХЗХ нь уг хөтөлбөрийг

батлагдсанаас хойш шинээр байгуулагдсан ба хөтөлбөрөөс нийт 11,511,938.9 мянган төгрөгийн зээл санхүүжилтийг авсан байна.

Тайлант жилд дээрх 118 ХЗХ-оос 49 ХЗХ нь 160,094.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь салбарын нийт алдагдлын 33.1 хувьтай тэнцэж байна. Мөн 4 ХЗХ ашиг болон алдагдалгүй, 65 ХЗХ 52,369.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. Тус ХЗХ-дын нийт хүүгийн орлого 568,468.4 мянган төгрөг, үйл ажиллагааны зардал 676,193.1 мянган төгрөг, тайлант үеийн ашиг, алдагдал нь 107,724.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 95.3 хувиар буюу 52,572.1 мянган төгрөгөөр өссөн байна.

### ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

#### 3.1 Хөрөнгийн бүтэц

ХЗХ-дын тайлант улирлын нийт хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

(мянган төгрөгөөр)

№	ХӨРӨНГӨ	2016 оны I улирал		2017 оны I улирал		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		99,292,821.6	97.8%	118,812,037.6	97.6%	19,519,216.0	19.7%
1.1	МӨНГӨН ХӨРӨНГӨ	16,596,007.1	16.3%	20,026,700.0	16.5%	3,430,692.9	20.7%
	Бэлэн мөнгө	1,836,207.3	1.8%	2,546,711.0	2.1%	710,503.7	38.7%
	Банкинд байршуулсан харилцах	2,998,204.6	3.0%	7,187,989.6	5.9%	4,189,785.0	139.7%
	Банкинд байршуулсан хадгаламж	11,761,595.2	11.6%	10,291,999.4	8.5%	(1,469,595.8)	(12.5%)
1.2	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-	-	-	-	-
	Арилжааны үнэт цаас	-	-	-	-	-	-
1.3	ЗЭЭЛ /ЦЭВРЭЭР/	78,198,418.3	77.0%	93,437,634.6	76.8%	15,239,216.3	19.5%
	<b>Нийт зээл</b>	80,318,082.9	79.1%	96,733,750.1	79.5%	16,415,667.2	20.4%
	Хэвийн зээл	73,194,302.4	72.1%	87,220,700.6	71.7%	14,026,398.2	19.2%
	Хугацаа хэтэрсэн зээл	3,666,679.8	3.6%	5,028,145.6	4.1%	1,361,465.8	37.1%
	Чанаргүй зээл	3,457,100.7	3.4%	4,484,903.8	3.7%	1,027,803.1	29.7%
	Хэвийн бус зээл	1,337,137.9	1.3%	1,339,030.0	1.1%	1,892.1	0.1%
	Эргэлзээтэй зээл	1,059,290.8	1.0%	943,963.6	0.8%	(115,327.2)	(10.9%)
	Муу зээл	1,060,672.0	1.0%	2,201,910.3	1.8%	1,141,238.3	107.6%


	(Зээлийн эрсдэлийн сан )	2,119,664.6	2.1%	3,296,115.5	2.7%	1,176,450.9	55.5%
1.4	АВЛАГА	3,546,559.4	3.5%	4,138,107.3	3.4%	591,547.9	16.7%
	Байгууллага, хүмүүсээс авах авлага	238,290.1	0.2%	474,705.0	0.4%	236,414.9	99.2%
	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	3,308,269.4	3.3%	3,663,402.3	3.0%	355,132.9	10.7%
1.5	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	308,640.6	0.3%	394,369.5	0.3%	85,728.9	27.8%
	Татварын авлага	18,147.3	-	423,518.4	0.3%	405,371.1	2,233.8 %
	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	48,352.4	-	96,148.9	0.1%	47,796.5	98.9%
	Дараа тайлангийн тооцоо	57,847.6	0.1%	23,544.5	-	(34,303.1)	(59.3%)
	Дутагдал, шамшигдал	115,207.2	0.1%	115,020.8	0.1%	(186.4)	(0.2%)
	Хангамжийн зүйлс	69,086.1	0.1%	117,303.8	0.1%	48,217.7	69.8%
	Салбар хоорондын авлага	-	-	-	-	-	-
1.6	ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ /ЦЭВРЭЭР/	643,196.2	0.6%	815,226.2	0.7%	172,030.0	26.7%
	Өмчлөх бусад хөрөнгө	733,150.5	0.7%	857,571.5	0.7%	124,421.0	17.0%
	(Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулга)	89,954.3	0.1%	42,345.4	-	(47,608.9)	(52.9%)
2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		2,233,610.3	2.2%	2,886,243.7	2.4%	652,633.4	29.2%
2.1	ҮНДСЭН ХӨРӨНГӨ /ЦЭВРЭЭР/	2,209,828.1	2.2%	2,854,268.8	2.3%	644,440.7	29.2%
	Үндсэн хөрөнгө	2,797,201.9	2.8%	3,536,238.6	2.9%	739,036.7	26.4%
	(Хуримтлагдсан элэгдэл)	587,373.8	0.6%	681,969.8	0.6%	94,596.0	16.1%
2.2	БИЕТ БУС ХӨРӨНГӨ	8,762.2	-	16,954.9	-	8,192.7	93.5%
	Биет бус хөрөнгө	10,741.3	-	18,624.1	-	7,882.8	73.4%
	(Биет бус хөрөнгийн элэгдэл)	1,979.2	-	1,669.2	-	(310.0)	(15.7%)
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	15,020.0	-	15,020.0	-	-	-
2.3	Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө	15,020.0	-	15,020.0	-	-	-
ХӨРӨНГИЙН ДҮН		101,526,431.9	100.0%	121,698,281.4	100.0%	20,171,849.5	19.9%



Активын хэмжээ өмнөх онтой харьцуулахад 19.9 хувиар буюу 20,171,849.5 мянган төгрөгөөр, ХЗХ-дын банкинд байршуулсан хадгаламжийн хэмжээ 10,291,999.4 мянган төгрөгөөр буюу 12.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант улиралд чанаргүй зээлийн хэмжээ 1,027,803.1 мянган төгрөгөөр буюу өмнөх оны мөн үеэс 29.7 хувиар өссөн ба үүнийг дагаад зээлийн эрсдэлээс хамгаалах сан 1,176,450.9 мянган төгрөгөөр буюу 55.5 хувиар өссөн байгааг анхаарч зээлийн чанар муудаж байгаа ХЗХ-дод тавих хяналтыг сайжруулах нь зүйтэй гэж үзэж байна.

ХЗХ-дын тоо болон нийт активын өөрчлөлтийг харьцуулж үзүүлбэл :



### 3.2 Активын төвлөрлийг активын хэмжээ болон гишүүдийн тоогоор нь авч үзвэл

Үүнд: Активын хэмжээгээр:


(мянган төгрөгөөр)

№	Активын хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт актив		Гишүүдийн тоо	
			Дүн	Хувь	Тоо	Хувь
1	10,000,000.0 дээш	2	51,485,957.8	42.3%	5,648	11.8%
2	1,000,000.0-10,000,000.0	13	35,613,442.1	29.3%	9,501	19.8%
3	500,000.0-1,000,000.0	11	7,940,670.2	6.5%	4,454	9.3%
4	100,000.0-500,000.0	152	23,018,236.2	18.9%	20,034	41.8%
5	50,000.0-100,000.0	26	1,885,521.6	1.5%	3,594	7.5%
6	10,000.0-50,000.0	51	1,647,244.3	1.4%	3,949	8.2%
7	10,000.0 хүртэл	27	107,209.2	0.1%	738	1.5%
	Нийт дүн	282	121,698,281.4	100.0%	47,918	100.0%

ХЗХ-дыг активын хэмжээгээр ангилахад томоохон буюу 1.0 тэрбум төгрөгөөс дээш актив хөрөнгөтэй 15 ХЗХ-ны нийт актив 87,099,399.9 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын активын 71.6 хувийг, гишүүдийн тоо 15,149 байгаа нь нийт ХЗХ-дын гишүүдийн 31.6 хувийг тус тус эзэлж байна.

### 3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар


Зээлийн чанарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:



Цэвэр зээлийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15,239,216.3 мянган төгрөгөөр буюу 19.5 хувиар өссөн бол хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 1,361,465.9 мянган төгрөгөөр буюу 37.1 хувиар, чанаргүй зээлийн үлдэгдэл 1,027,803.2 мянган төгрөгөөр буюу 29.7 хувиар өссөн байна.

Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үед 4.3 хувь байсан бол тайлант улиралд 4.6 хувь болж өссөн байна.

Зээлийн багцын өөрчлөлтийг харьцуулж харуулбал:



ХЗХ-дын нийт зээлийн багц 96,733,750.1 мянган төгрөг байгаа нь активын 79.5 хувьтай, цэвэр зээл 93,437,634.6 мянган төгрөг байгаа нь активын 76.8 хувьтай тус тус тэнцэж байна.

## ДӨРӨВ. НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

### 4.1 Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн талаар

Тайлант улирлын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд: (мянган төгрөгөөр)

№	ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2016 оны I улирал		2017 оны I улирал		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь


1. ӨР ТӨЛБӨР		81,001,547.3	79.8%	98,064,292.4	80.6%	17,062,745.1	17.4%
1.1	ХАДГАЛАМЖ	62,808,344.1	61.9%	74,658,800.4	61.3%	11,850,456.3	15.9%
	Хугацаагүй	2,236,258.5	2.2%	2,311,701.9	1.9%	75,443.4	3.3%
	Хугацаатай	60,572,085.6	59.7%	72,347,098.5	59.4%	11,775,012.9	16.3%
1.2	БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ	1,379,781.9	1.4%	3,253,559.2	2.7%	1,873,777.3	57.6%
	Банкнаас авсан зээл	614,145.3	0.6%	1,671,740.8	1.4%	1,057,595.5	63.3%
	Санхүүгийн байгууллагаас авсан зээл	400,210.0	0.4%	48,689.8	0.04%	(351,520.2)	(87.8%)
	Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	365,426.6	0.4%	1,533,128.6	1.3%	1,167,702.0	76.2%
	Тогтворжилтын сангийн санхүүгийн туслалцаа	-	-	-	-	-	-
1.3	БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,843,749.9	4.8%	6,572,121.5	5.4%	1,728,371.6	26.3%
	Цалингийн өглөг	43,031.7	-	53,290.4	0.04%	10,258.7	19.3%
	Татвар, НДШ, ЭМДШ-ийн өглөг	236,638.5	0.2%	256,924.1	0.2%	20,285.6	7.9%
	Ногдол ашгийн өглөг	444,958.1	0.4%	1,305,426.3	1.1%	860,468.2	65.9%
	Санхүүгийн түрээсийн өглөг	-	0.0%	1,618.5	0.001%	1,618.5	100.0%
	Санхүүгийн түрээсийн хэрэгжээгүй орлого	-	-	26.6	-	26.6	100.0%
	Урьдчилж орсон орлого	27,434.8	-	115,262.3	0.1%	87,827.5	76.2%
	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	3,957,933.8	3.9%	4,746,335.5	3.9%	788,401.7	16.6%
	Салбар хоорондын тооцоогоорх өглөг	-	-	2,384.9	-	2,384.9	100.0%
	Бусад богино хугацаат өглөг	133,753.1	0.1%	90,852.8	0.1%	(42,900.3)	(47.2%)
1.4	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,969,671.3	11.8%	13,579,811.3	11.2%	1,610,140.0	11.9%
	Банкнаас авсан зээл	294,627.2	0.3%	439,839.7	0.4%	145,212.5	33.0%
	Санхүүгийн байгууллагаас авсан зээл	154,479.4	0.2%	549,640.2	0.5%	395,160.8	71.9%
	Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	11,517,049.5	11.3%	12,389,197.1	10.2%	872,147.6	7.0%
	Тогтворжилтын сангийн санхүүгийн туслалцаа	-	-	200,000.0	0.2%	200,000.0	100.0%
	Хойшлогдсон татварын өр төлбөр	3,515.3	-	1,134.3	-	(2,381.0)	(67.7%)
2. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		20,524,884.6	20.2%	23,633,988.9	19.4%	3,109,104.3	15.1%
2.1	ГИШҮҮДИЙН ОРУУЛСАН ХУВЬ ХӨРӨНГӨ	11,107,870.4	10.9%	13,421,049.0	11.0%	2,313,178.6	20.8%
	Гишүүний оруулсан хувь хөрөнгө	11,082,206.5	10.9%	13,402,670.8	11.0%	2,320,464.3	17.3%

	Идэвхгүй гишүүний оруулсан хувь хөрөнгө	25,663.9	0.0%	18,378.2	0.0%	(7,285.7)	(28.4%)
2.2	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ	51,305.2	0.1%	159,832.9	0.1%	108,527.7	211.5%
	Дахин үнэлгээний нэмэгдэл	51,305.2	0.1%	159,832.9	0.1%	108,527.7	211.5%
2.3	ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ	9,365,709.0	9.2%	10,053,107.1	8.3%	687,398.1	7.3%
	Нөөцийн сан	2,733,768.3	2.7%	3,104,991.6	2.6%	371,223.3	13.6%
	Хандив, тусламж	78,696.0	0.1%	192,904.4	0.2%	114,208.4	145.1%
	Хадгаламж, хамгаалалтын сан	669,650.3	0.7%	828,197.5	0.7%	158,547.2	23.7%
	Нийгмийн хөгжлийн сан	627,054.6	0.6%	738,599.8	0.6%	111,545.2	17.8%
	Тогтворжилтын сан	675,430.9	0.7%	837,742.8	0.7%	162,311.9	24.0%
	Бусад сангууд	815,090.9	0.8%	921,651.2	0.8%	106,560.3	13.1%
	Хуримтлагдсан орлого /алдагдал/	3,766,018.0	3.7%	3,429,019.8	2.8%	(336,998.2)	(8.9%)
	Тайлангийн үеийн цэвэр орлого	622,399.3	0.6%	484,070.4	0.4%	(138,328.9)	(22.2%)
	Өмнөх үеийн цэвэр орлого	3,143,618.8	3.1%	2,944,949.4	2.4%	(198,669.4)	(6.3%)
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>101,526,431.9</b>	<b>100.0%</b>	<b>121,698,281.4</b>	<b>100.0%</b>	<b>20,171,849.5</b>	<b>19.9%</b>

ХЗХ-дын өр төлбөр, өөрийн хөрөнгийн хэмжээ буюу эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17,062,745.1 мянган төгрөгөөр буюу 17.4 хувиар өссөн.

Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн өөрчлөлтийг харьцуулж үзүүлбэл:

(тэрбум төгрөгөөр)



#### 4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 74,658,800.4 мянган төгрөг буюу нийт өр төлбөрийн 76.1 хувийг эзэлж байна.

ХЗХ-дын хадгаламжийн хэмжээгээр бүлэглэн харуулбал:

(мянган төгрөгөөр)

№	Хадгаламжийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хадгаламжийн дүн	Нийт хадгаламжид эзлэх хувь
1	10,000,000.0 дээш	1	29,574,447.9	39.6 %
2	1,000,000.0-10,000,000.0	10	31,582,284.4	42.3 %
3	500,000.0-1,000,000.0	5	3,261,241.0	4.4 %
4	100,000.0-500,000.0	30	6,669,727.9	8.9 %
5	50,000.0-100,000.0	16	1,180,691.3	1.6 %
6	10,000.0-50,000.0	93	1,910,054.1	2.6 %
7	5,000.0-10,000.0	50	360,998.2	0.48 %
8	5,000.0 хүртэл	54	119,355.6	0.16 %
9	Хадгаламжгүй	23	-	-
<b>НИЙТ ХАДГАЛАМЖИЙН ДҮН</b>		<b>282</b>	<b>74,658,800.4</b>	<b>100.0%</b>

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад 1,000,000.0 мянган төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй 11 ХЗХ-ны хадгаламжийн үлдэгдэл 61,156,732.3 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын хадгаламжийн үлдэгдлийн 81.9 хувийг эзэлж байгаа бол хадгаламж татан төвлөрүүлээгүй 23 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-дын 8.1 хувийг эзэлж байна.

1,000,000.0 мянган төгрөгөөс дээш хэмжээтэй хадгаламжийн үлдэгдэлтэй буюу хадгаламжийн төвлөрөл ихтэй 11 ХЗХ-ны мэдээлэл дараах байдалтай байна.

(мянган төгрөгөөр)

№	ХЗХ-дын нэрс	Хадгаламжийн үлдэгдэл	Нийт хадгаламжид эзлэх хувь	Нийт актив	Тухайн ХЗХ-ны активт хадгаламжийн эзлэх хувь
1	Номин юнион	29,574,447.9	39.6%	39,620,896.9	74.6%
2	Сидан	9,907,154.5	13.3%	11,865,060.8	83.5%
3	Май капитал	5,016,670.1	6.7%	7,541,793.5	66.5%
4	Монкорд	4,830,606.9	6.5%	6,726,023.8	71.8%
5	Арвайн үр	1,979,831.9	2.7%	2,759,454.5	71.7%
6	Мон сант алдар	1,921,031.5	2.6%	2,688,124.5	71.5%
7	Эмпипи	1,833,147.6	2.5%	2,416,771.6	75.9%
8	Кредит юнион монгол	1,705,791.7	2.3%	3,003,106.4	56.8%
9	Гялс төгрөг	1,603,374.8	2.1%	2,004,557.7	80.0%
10	Алтан давалгаа	1,530,251.4	2.0%	2,213,429.2	69.1%
11	Монос дэлгэрэх	1,254,423.9	1.7%	1,471,699.6	85.2%
<b>НИЙТ</b>		<b>61,156,732.2</b>	<b>81.9%</b>	<b>82,310,918.5</b>	<b>74.3%</b>

Салбарын хэмжээгээр нийт хадгаламжийн өсөлтийг харуулбал:

(тэрбум төгрөгөөр)

**4.3 Бусдаас авсан зээл**

(мянган төгрөгөөр)

№	Бусдаас авсан зээл	Нийт	УБ хот	Орон нутаг
			Дүн	Дүн
1	Банкнаас авсан зээл	2,111,580.6	1,540,312.8	571,267.7
2	Санхүүгийн байгууллагаас авсан зээл	598,329.9	457,336.7	140,993.2
3	Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	13,922,325.7	13,886,800.0	35,525.6

**4.4 Хувь хөрөнгийн талаар**


Тайлант улиралд гишүүдийн хувь хөрөнгийн хэмжээ 13,421,048.9 мянган төгрөг байгаа нь нийт эх үүсвэрийн 56.8 хувийг эзэлж байна. Үүнийг интервалаар харуулбал:

(мянган төгрөгөөр)

д/д	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Гишүүдийн тоо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн	
				Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	2	5,130	4,101,707.9	30.6%
2	500,000.0-1,000,000.0	1	316	584,800.9	4.4%
3	100,000.0-500,000.0	22	13,313	4,466,941.4	33.3%
4	50,000.0-100,000.0	20	13,542	1,448,210.2	10.8%
5	10,000.0-50,000.0	88	5,409	2,052,361.7	15.3%
6	5,000.0-10,000.0	83	7,052	578,334.7	4.3%
7	5,000.0 хүртэл	66	3,156	188,692.2	1.4%
Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн		282	47,918	13,421,049.0	100.0%

ХЗХ-дын хувь хөрөнгийн өсөлтийг өмнөх жилүүдтэй харьцуулвал:

(тэрбум төгрөгөөр)



#### 4.5 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын өөрийн хөрөнгө 23,149,918.5 мянган төгрөг байгаа нь нийт эх үүсвэрийн 19.02 хувийг эзэлж байна. Үүнийг бүлэглэн харуулбал дараах байдалтай байна.

(мянган төгрөгөөр)

д/д	Өөрийн хөрөнгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Өөрийн хөрөнгө	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	3	9,221,775.8	39.8
2	500,000.0-1,000,000.0	4	2,249,877.4	9.7
3	100,000.0-500,000.0	33	7,430,633.3	32.1
4	50,000.0-100,000.0	24	1,656,131.2	7.2
5	10,000.0-50,000.0	84	2,094,468.1	9.0
6	10,000.0 доош	117	568,847.6	2.5
7	Өөрийн хөрөнгөгүй	17	-71,814.9	(0.3)
Нийт өөрийн хөрөнгийн дүн		282	23,149,918.5	100.0

ХЗХ-дын хоршоологчдын өмчийн байдлыг бүлэглэн харуулбал. Үүнд: (мянган төгрөгөөр)

д/д	Хоршоологчдын өмчийн дүн /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хоршоологчдын өмчийн дүн	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	1	3,630,656.1	36.1%
2	500,000.0-1,000,000.0	2	1,544,081.4	15.4%
3	100,000.0-500,000.0	17	3,297,953.1	32.8%
4	50,000.0-100,000.0	8	603,261.6	6.0%
5	10,000.0-50,000.0	52	1,184,448.3	11.8%
6	5,000.0-10,000.0	28	203,276.8	2.0%
7	1,000.0-5,000.0	56	150,901.2	1.5%
8	1,000.0 хүртэл	29	10,742.7	0.1%
9	Хоршоологчдын өмчгүй /алдагдалтай/	89	-572,214.1	(5.7%)
Нийт дүн		282	10,053,107.1	100.0%

## ТАВ. ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

## 5.1 ХЗХ-дын орлогын үзүүлэлтүүд

Орлогын бүтцийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

(мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	3/31/2016		3/31/2017		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
I ХҮҮГИЙН ОРЛОГО	5,862,272.9	96.5%	6,447,135.5	93.0%	584,862.6	10%
Зээлийн хүүгийн орлого	5,658,446.0	93.1%	6,150,958.2	88.7%	492,512.2	8.7%
Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого	77,154.8	1.3%	105,173.6	1.5%	28,018.8	36.3%
Үнэт цаасны хүүгийн орлого	-	0.0%	96.0	-	96.0	-
Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого	161,704.7	2.7%	209,107.9	3.0%	47,403.2	29.3%
(Зээлийн хүүгийн орлогын буцаалт)	35,032.5	0.6%	18,200.3	0.3%	(16,832.2)	(48.0%)
IV ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО	123,512.8	2.0%	186,905.6	2.7%	63,392.8	51.3%
Элсэлтийн хураамж	18,960.5	0.3%	10,806.0	0.2%	(8,154.5)	(43.0%)
Гишүүний татвар	21,217.2	0.3%	16,295.4	0.2%	(4,921.9)	(23.2%)
Үйлчилгээний шимтгэл, хураамж	81,269.3	1.3%	90,970.3	1.3%	9,701.0	11.9%
Түрээсийн орлого	2,065.9	0.0%	3,900.5	0.1%	1,834.6	88.8%
Санхүүгийн бусад ажил, үйлчилгээний орлого	-	0.0%	64,933.4	0.9%	-	-
VI ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	91,581.8	1.5%	300,169.3	4.3%	208,587.5	227.8%
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	440.5	0.0%	440.5	-	-	-
Бусад орлого	91,141.2	1.5%	299,728.7	4.3%	208,587.5	228.9%
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>6,077,367.5</b>	<b>100%</b>	<b>6,934,210.3</b>	<b>100%</b>	<b>856,842.8</b>	<b>14.1%</b>

ХЗХ-дын нийт орлого өмнөх оны мөн үеэс 856,842.8 мянган төгрөгөөр буюу 14.1 хувиар өсөж 6,934,210.3 мянган төгрөгт хүрсэн байна. Энэхүү өсөлтөд зээлийн хүүгийн орлого 492,512.2 мянган төгрөгөөр буюу 8.7 хувиар, үйл ажиллагааны бусад орлого 63,392.8 мянган төгрөгөөр буюу 51.3 хувиар, үйл ажиллагааны бус орлого 208,587.5 мянган төгрөгөөр буюу 227.8 хувиар тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

## 5.2 ХЗХ-дын зардлын үзүүлэлтүүд

Зардлын бүтцийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

(мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	3/31/2016		3/31/2017		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
II ХҮҮГИЙН ЗАРДАЛ	3,079,560.7	56.5%	3,492,883.0	54.2%	413,322.3	13.4%
Хадгаламжийн хүүгийн зардал	2,948,228.9	54.0%	3,391,725.5	52.6%	443,496.6	15.0%




Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	111,372.5	2.0%	87,714.0	1.4%	-23,658.5	(21.2%)
Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал	250.0	-	2,165.6	-	1,915.6	766.2%
Бусад хүүгийн зардал	19,887.6	0.4%	11,804.8	0.2%	-8,082.8	(40.6%)
(Хүүгийн зардлын буцаалт)	178.2	-	527.0	-	348.8	195.7%
<b>III БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>248,096.5</b>	<b>4.5%</b>	<b>794,304.7</b>	<b>12.3%</b>	<b>546,208.2</b>	<b>220.2%</b>
Зээлийн эрсдэлийн зардал	292,305.7	5.4%	811,273.1	12.6%	518,967.4	177.5%
Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал	1,088.8	0.0%	4,745.2	0.1%	3,656.4	335.8%
(Болзошгүй эрсдэлийн сангийн нөхөлт)	45,298.0	0.8%	21,713.6	0.3%	-23,584.4	(52.1%)
<b>V ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>1,832,791.9</b>	<b>33.6%</b>	<b>2,035,819.1</b>	<b>31.6%</b>	<b>203,027.2</b>	<b>11.1%</b>
Боловсон хүчний зардал	1,161,005.7	21.3%	1,270,611.9	19.7%	109,606.2	9.4%
Бусад төрлийн зардал	671,786.2	12.3%	765,207.3	11.9%	93,421.1	13.9%
<b>VII ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>	<b>181,181.8</b>	<b>3.3%</b>	<b>36,429.1</b>	<b>0.6%</b>	<b>-144,752.7</b>	<b>(79.9%)</b>
<b>IX ТАТВАРЫН ЗАРДАЛ</b>	<b>113,337.3</b>	<b>2.1%</b>	<b>90,704.0</b>	<b>1.4%</b>	<b>-22,633.3</b>	<b>(20.0%)</b>
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>5,454,968.2</b>	<b>100%</b>	<b>6,450,139.9</b>	<b>100%</b>	<b>995,171.7</b>	<b>18.2%</b>
<b>НИЙТ АШИГ</b>	<b>622,399.3</b>	<b>100%</b>	<b>484,070.4</b>	<b>100%</b>	<b>-138,328.9</b>	<b>(22.2%)</b>

ХЗХ-дын нийт зардлын хэмжээ 6,450,139.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 995,171.7 мянган төгрөгөөр буюу 18.2 хувиар өссөн байна.

### 5.3 Ашигт ажиллагааг өмнөх жилүүдийн мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

Үүнд:



### 5.4 Ашигтай ажиллаж буй ХЗХ-д

Тайлант улиралд 169 ХЗХ-д 865,150.2 мянган төгрөгийн ашигтай, 19 ХЗХ ашиг, алдагдалгүй, 94 ХЗХ 381,079.8 мянган төгрөгийн алдагдалтай тус тус ажиллаж салбарын хэмжээнд нийт 484,070.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Салбарын ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 138,328.9 мянган төгрөгөөр буюу 22.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Ашигтай ажилласан ХЗХ-дыг бүлэглэн харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

(мянган төгрөгөөр)

Ашгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Ашгийн хэмжээ	Нийт ашигт эзлэх хувь	Активын хэмжээ	Активын өгөөж
100,000.0 дээш	2	294,446.0	34.0%	19,406,854.4	1.52%
50,000.0-100,000.0	-	-	-	-	-
10,000.0-50,000.0	13	310,276.4	35.9%	14,809,504.2	2.1%
5,000.0-10,000.0	13	94,863.8	11.0%	5,567,792.7	1.7%
1,000.0-5,000.0	58	138,416.1	16.0%	12,578,104.3	1.1%
1,000.0 хүртэл	83	27,147.8	3.1%	10,923,935.7	0.2%
Ашиг, алдагдалгүй	19	-	-	497,858.6	-
Нийт дүн	188	865,150.1	100%	63,784,049.8	1.4%

**5.5 Алдагдалтай ажиллаж буй ХЗХ-д**

Нийт 282 ХЗХ-ны 33.3 хувь буюу 94 ХЗХ 381,079.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Үүнд:

(мянган төгрөгөөр)

д/д	Алдагдлын хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Алдагдлын хэмжээ	Нийт алдагдалд эзлэх хувь
1	10,000.0 дээш	11	264,006.6	69.3%
2	5,000.0-10,000.0 хүртэл	4	27,855.5	7.3%
3	1,000.0-5,000.0 хүртэл	29	66,839.6	17.5%
4	1,000.0 хүртэл	50	22,378.1	5.9%
	Нийт дүн	94	381,079.8	100%

Алдагдалтай ажиллаж байгаа ХЗХ-дын 66.7 хувь Улаанбаатар хотод, 33.3 хувь нь хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

### ЗУРГАА. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

ХЗХ-дын 2016 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 2014 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон дагаж мөрдөх үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

№	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	ЗХШҮ /ДМҮ	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАНГААР
<b>А</b>	<b>ХӨРӨНГИЙН ЧАНАР БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ</b>			
1	ХӨРӨНГИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (мянган төгрөг)		15,187.0	15,187.0
2	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	5%-иас бага	4.74%
3	НЭГ ГИШҮҮНД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ДМҮ	30%-иас бага	8.55%
4	НЭГ ДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ХАРЬЦАА	ДМҮ	30%-иас бага	0.00%
<b>Б</b>	<b>ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>			
1	НИЙТ ХӨРӨНГӨ /АКТИВ/-Д ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	60% - 85%	84.69%
2	ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ДМҮ	5% -иас бага	

3	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ДМҮ	10%-иас бага	0.73%
4	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	20% - 80%	51.08%
5	БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ДМҮ	20%-иас бага	0.00%
6	НЭГ ГИШҮҮНИЙ ОРУУЛЖ БОЛОХ ХУВЬ ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	10%-иас бага	10.00%
7	ХОРШООЛОГЧДЫН ӨМЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	5%-иас их	18.02%
8	НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ (мянган төгрөг)	ДМҮ	11,692,431.0	22,490,000.0
9	ХАДГАЛАМЖ ХАМГААЛАЛТЫН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ (мянган төгрөг)	ДМҮ	5,846,215.5	12,270,000.0
10	ТОГТВОРЖИЛТЫН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ (мянган төгрөг)	ДМҮ	5,846,215.5	12,270,000.0
<b>В</b>	<b>ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ</b>			
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ДМҮ	15%-иас бага	2.49%
<b>Г</b>	<b>ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР</b>			
12	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	5%-иас их	36.48%
<b>Д</b>	<b>ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ (ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ)</b>			
13	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ӨГӨӨЖ			2.26%

### ДОЛОО. ДҮГНЭЛТ

2017 оны 1 дүгээр улиралд 2 ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож, 16 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 3 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж 282 ХЗХ Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Тайлант улирлын санхүүгийн үзүүлэлтүүдийг авч үзвэл:

#### 1. Нийт актив

Тайлант хугацаанд ХЗХ-дын активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20,171,849.5 мянган төгрөгөөр буюу 19.9 хувиар өсч 121,698,281.4 мянган төгрөгт хүрсэн нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 0.5 хувьтай тэнцэж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-дын хувьд гишүүдийн тоо 3,580-аар, нийт актив 17,916,505.7 мянган төгрөгөөр буюу 20,5 хувиар, орон нутгийн ХЗХ-дын хувьд гишүүдийн тоо 2,521-ээр өсч, нийт актив 2,255,343.8 мянган төгрөгөөр буюу 15.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

#### 2. Нийт зээлийн үлдэгдэл

Нийт зээлийн үлдэгдэл 96,733,750.1 мянган төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 0.7 хувьтай тэнцэж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн багц 16,415,667.2 мянган төгрөгөөр буюу 20.4 хувиар, чанаргүй зээлийн хэмжээ 1,027,803.1 мянган төгрөг буюу 29,7 хувиар тус тус өссөн байна. Чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдсэнээр зээлийн эрсдэлээс хамгаалах сан 1,176,450.9 мянган төгрөгөөр буюу 55,5 хувиар өссөн байна.

Мөн нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ өнгөрсөн оны мөн үед 3.4 хувь байсан бол тайлант улиралд 3.7 хувь болж өссөн байна.

#### 3. Татан төвлөрүүлсэн хадгаламж

Нийт хадгаламжийн үлдэгдэл 74,658,800.4 мянган төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 0.8 хувьтай тэнцэж байна. Хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 11,850,456.3 мянган төгрөгөөр буюу 18.9 хувиар өссөн байна.

#### 4. Хувь хөрөнгийн хэмжээ

Хувь хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,313,178.5 мянган төгрөгөөр буюу 20.8 хувиар өсч, гишүүдийн тоо 6,101-ээр нэмэгдсэн байна. Нийт хувь хөрөнгө тайлант онд 13,421,048.9 мянган төгрөг байгаа ба үүний 99.9 хувь буюу 13,402,670.7 мянган төгрөг нь идэвхтэй гишүүний хувь хөрөнгө бол 0.1 хувь буюу 18,378.2 мянган төгрөг нь идэвхгүй гишүүний хувь хөрөнгө байна.

#### 4. Хоршоологчдын өмч

Хоршоологчдын өмчийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 687,398.1 мянган төгрөгөөр буюу 7.3 хувиар өссөн. Салбарын хэмжээнд хувь хөрөнгө болон хоршоологчдын өмчийн хэмжээ өссөн хэдий ч нэр бүхий 89 ХЗХ хоршоологчдын өмчгүй болсон байгааг Хорооноос анхаарч ажиллах хэрэгтэй.

Мөн нэр бүхий 17 ХЗХ алдагдалтай ажиллаж, өөрийн хөрөнгөгүй болсон нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 56.5-д "Санхүү төлбөрийн чадвар муудсан, өөрийн хөрөнгөгүй болсон тухай бүр ХЗХ-ны үйл ажиллагаанд Хорооноос хяналт шалгалтыг хийнэ" заасан нөхцөл бүрдсэн гэж үзэж байна.

#### 5. Нийт орлого, ашиг

ХЗХ-дын нийт орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 856,842.8 мянган төгрөгөөр буюу 14.1 хувиар, нийт зардлын хэмжээ 995,171.7 мянган төгрөгөөр буюу 18.2 хувиар тус тус өсч тайлант улирлын байдлаар цэвэр ашиг 484,070.4 мянган төгрөг байна. Тайлант үеийн ашгийг өмнөх оны мөн үеийн байдалтай харьцуулахад 138,328.9 мянган төгрөгөөр буюу 22.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ХЗХ-дын нийт зардлын хэмжээ 6,450,139.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 995,171.7 мянган төгрөгөөр буюу 18.2 хувиар өссөн байна.

#### 6. Зохистой харьцааны үзүүлэлт

Тайлант улирлын байдлаар Хорооноос журмаар тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн заавал дагаж мөрдөх үзүүлэлтийг 47 ХЗХ бүрэн хангаж ажилласан, 78 ХЗХ 1 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй, 67 ХЗХ 2 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй, 68 ХЗХ 3 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй, 14 ХЗХ 4 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй, 3 ХЗХ 5 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй үзүүлэлттэй байна.

ХЗХ-дын хөрөнгө, зээл, хадгаламж, орлого, гишүүдийн тоо зэрэг үндсэн үзүүлэлтүүд өссөн байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулж үр дүнг нэгтгэн дүгнэвэл нийт активын хэмжээ 19.9 хувиар, нийт зээлийн хэмжээ 20.24 хувиар өсч, нийт орлого 14.1 хувиар нэмэгдсэн байна.

Газар дээрх болон зайны хяналтыг сайжруулж, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тооцох ажлыг эрчимжүүлж хяналт шалгалтыг сайжруулах шаардлагатай байгаа бөгөөд тайлан мэдээ гаргах, нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой гарсан алдаа, зөрчил дутагдалыг гарсан даруйд нь ХЗХ-дод тайлангийн хариугаар албан бичгээр хүргүүлж хэвших хэрэгтэй байна.

## **ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР**